



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

# “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.2, 62 дугаар зүйлийн 62.1, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А-1/598 дугаар удирдамж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11.00 цагт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлыг хавсралтаар баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр даргалуулсугай.

4. Хувьцаа эзэмшигчид хурлын зарыг хүргүүлэх, хуульд заасан бичиг баримтыг танилцуулах, хурлын бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Отгонсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОДХҮҮ